




ХАРИЛЦАГЧИЙН ГАРЫН АВЛАГА



SBT Co.,Ltd нь 1993 онд Япон улсад үүсгэн байгуулагдаж, Олон улсад автомашины захиалга зуучлалын чиглэлээр үйл ажиллагаагаа тогтвортой явуулж буй автомашин импортлогч анхдагч тэргүүлэгч компаниудын нэг юм.

Манай компанийн төв оффис Японы Ёкохама хотод байрлах бөгөөд орон даяар 6 салбартай, дэлхийд 33 салбар оффистой бөгөөд олон улсад худалдаа эрхэлж буй шилдэг экспортлогч компаниудын нэг юм.



📍 Монгол дах салбар оффис

SBT Mongolia LLC

TEL: (976) 75557777

Address: Mongolia, Ulaanbaatar – 14210

Sukhbaatar district, 1st khoroo, Peace avenue,

Narnii zam-91, Sunroad office 9f 903

MAIL ADDRESS: sbtsalesmongolia@sbtjapan.com

WEB SITE: <http://www.sbtjapan.com>

БИДНИЙ ДАВУУ ТАЛУУД

✓ Монголд салбартай, туршлагатай баг хамт олон

Монголдох салбараа бид 2012 онд байгуулж, автомашины захиалга зуучлалын чиглэлээр үйл ажиллагаагаа тогтвортой явуулж буй автомашин импортлогч анхдагч тэргүүлэгч компаниудын нэг юм.

✓ Япон орон даяар байрлах бүх дуудлага худалдаанд оролцох эрхтэй

Япон улсад байрлах бүх төрлийн авто машины нийт 170 гаруй дуудлага худалдаанд оролцож, машин сонгон авахаас эхлээд таны гарт хүрэх хүртэл дэмжлэг болох хамгийн сайн жуулчлалын үйлчилгээг танд үзүүлнэ.

✓ Ачигдахад бэлэн 20,000 гаруй автомашины СТОК-той

Та манай Японд байрлах СТОК-ноос ачигдахад бэлэн 20,000 гаруй автомашинаас сонголт хийх боломжтой.

✓ Өрсөлдөхүйц дотоод зардал /FOB/

Бидний Япон дах дотоод зардлын үнэ, ижил төрлийн үйл ажиллагаа явуулдаг компаниудтай харицуулахад өрсөлдөхүйц үнийг танд санал болгож байна

✓ Японы 4 боомтыг ашигладаг

Япон улсад өргөн цар хүрээнд байрлах **ЁКОХАМА, НАГОЯА, ОСАКА, ХАКАТА** зэрэг 4 боомтоос ачилтаа хийдэг бөгөөд эдгээр боомттой ойр байрлах дуудлага худалдаанаас машинаа сонговол дотоод зардал нь бага байх боломжтой.

✓ УБ хотод 4 гаалийг талбайг ашигладаг


Харилцагч та 3 тээврийн компаниас сонголтоо хийж, автомашинаа УБ хотод баруун, зүүн, төв хэсэгт байрлах **АМГАЛАН, ЭРИН, ПРОГРЕСТРАНС, ТУУШИН** зэрэг 4 гаалийн талбайд хүлээн авах боломжтой. Мөн бид Амгалан болон Эрин гаалийн талбайд SBT-ын яард хариуцсан 2 ажилтантай бөгөөд танд газар дээр нь олон төрлөөр тусламж үзүүлэх болно.

✓ SBT-Тээвэрлэлтийн даатгалтай

Бид харилцагчдынхаа ирээдүйд учирч болох санхүүгийн эрсдлээс хамгаалж хамгийн үр дүн өндөртэй буцаан олголт хийж чаддаг даатгалийн үйлчилгээгээ танд санал болгож байна. Та өөрийн худалдаж авсан машинаа тээвэрлэлтийн явцад үүсэж болох эрсдэлээс хамгаалж үнийн дүнгийн 1% аар даатгуулах боломжтой. Харин бид тээвэрлэлттэй холбоотой учирсан хохирлыг 99% шийдэж өгөх болно. Даатгалтай холбоотой дэлгэрэнгүй мэдээллийг хавсралтаас үзнэ үү.

✓ Төлбөрийн уян хатан нөхцөл

Бид төлбөрийн уян хатан нөхцөлтэй. Та өөрийн санхүүд тааруулж автомашиныхаа төлбөрийг 100%, 50/50% эсвэл 30/70% гэсэн нөхцөлөөр төлөх боломжтой.



Захиалга өгөх зааварчилгаа

I алхам. Бүртгүүлэх

Та автомашины захиалга өгөхөөсөө өмнө манай компанид харилцагчаар бүртгүүлэх шаардлагатай. Ингэснээр та манай ЦАХИМ ХУУДСАНД өөрийн гэсэн MYPAGE хуудастай болж хувийн мэдээлэл болон худалдан авалтынхаа тухай мэдээллийг хянах боломжтой.

Бүртгүүлэхэд шаардлагатай зүйлс:

1. Бүртгэлийн анкет
2. Худалдан авах гэрээ байгуулах
3. Иргэний үнэмлэх
4. Барьцаа (суудлын машин 100,000иен / ачааны машин 200,000иен)

*Барьцаа төлбөрийн нэхэмжлэлийг таны мэдээлэл манай системд ормогц, таны бүртгүүлсэн цахим шуудангаар танд очно.

Үүний дагуу шилжүүлсэн Барьцаа төлбөр нь таны дансанд байршмагц, дуудлага худалдаанд оролцох эрх тань нээгдэнэ.

II алхам. Худалдан авалт хийх

Худалдан авалт хийх үеийн зааварчилгаа болон зөвөлгөөг манай компаний туршлагатай худалдааны зөвлөх танд өгөх болно.

Машинаа яаж сонгох бэ

Тухайн машины дуудлага худалдааны хуудсыг хэрхэн зөв тайлж унших бэ /хавсралт/

Дуудлага худалдаанд хэрхэн үнэ хийж оролцох бэ

Нэг машин л авна, энэ үед яах ёстой бэ, юунд анхаарах бэ

Авч чадсан машиныхаа дотоод зардлыг нь хэрхэн тооцоолох бэ /хавсралт/

Монгол дох гаалийн татварын бодох аргачлал

Тээврийн зардлын зөвөлгөө зэрэг худалдан авалттай холбоотой бүх төрлийн зөвлөгөөнүүдийг манай худалдааны зөвлөх Танд өгөх болно.

АНХААРУУЛГА

Бүх худалдан авалт нь зөвхөн Харилцагчийн захиалгын дагуу хийгддэг бөгөөд таны захиалсан машинтай холбоотой гарч буй бүх зардал төлбөрийг захиалагч буюу харилцагч ТА хариуцах үүрэгтэй тул захиалгаа системд оруулахаасаа өмнө мэдээллээ дахин дахин нягталж захиалгаа өгнө үү.

Алдаатай буруу хийгдсэн захиалга болон Монгол руу тээвэрлэх боломжгүй болсон тээврийн хэрэгслийн ЗАХИАЛГА буюу ХУДАЛДАН АВАЛТ-ыг ЦУЦЛАХ үед дараах зардалууд гарч болзошгүй. Үүнд: захиалга цуцалсны торгууль, дуудлага худалдааны торгууль, дуудлага худалдаанд дахин оролцуулах зардал, үүнтэй холбоотойгоор гарах дотоод тээвэрлэлтийн зардлууд, зогсоол дээрх хадгалалтын зардал, зогсоол дээр хийгдсэн үзлэг засвар үйлчилгээний хөлс гэх мэт тухайн машинд холбоотой бусад зардлууд гарна.

III алхам. Тээвэрлэгч компаниа сонгох

Харилцагч таны худалдан авсан машин нь том жижиг хэмжээнээсээ хамаарч Японоос УБ хүртэлх тээвэрлэлтийн төрөл болон тээвэрлэлтийн компаниа сонгодог байгаа. Таны сонголтын дагуу SBT нь тээвэрлэлийн компанид таны мэдээллийг дамжуулах үүргийг гүйцэтгэдэг. **Тээвэрлэлтийн зардлыг тогтоох болон түүнтэй холбоотой төлбөрийг хүлээн авах нь Тээвэрлэлтийн компани болно.**

Тээвэрлэгч компаниа сонгохдоо анхаарах зүйлс:

Яагаад RORO-оор тээвэрлэдэг бэ?

- Автомашины том жижиг хэмжээнээс хамаарч Контейнер эсвэл RORO гэсэн 2 төрлөөс сонголтоо хийдэг.
- Ихэвчлэн ачааны том машинууд Контейнерт багтахгүй бол RORO-гоор явуулдаг.
- Түүнээс гадна таны авсан машин Контейнерт том зай эзэлж хамтад нь ачуулах, төлбөрөө хувааж төлөх өөр хүмүүс олдохгүй тохиолдолд RORO-г зөвлөх тохиолдол бас гарч болно. Энэ нь зарим тохиолдолд контейнерээс ч хямд тусах тохиолдол бий.
- Мөн энэ төрөл нь хамгийн эрсдэл / тээвэрлэлтийн явцад үүсч болох хохирол/ багатай тээвэрлэлтэд тооцогддог байгаа.

Харилцагч та худалдан авсан машинаа УБ хотод баруун, зүүн, төв хэсэгт байрлах Амгалан, Эрин, Прогрестранс, Туушин зэрэг 4 гаалийн талбайд хүлээн авах боломжтой бөгөөд үүнээс хамаарч 3 тээврийн компаниас сонголтоо хийж болно.

- ✧ Тээврийн зардалын хувьд тээвэрлэгч компаниасаа хамаарч үнэ нь өөр байдаг тул Худалдааны зөвлөхөсөө дэлгэрэнгүй мэдээлэл авч болно. Мөн тээвэрлэгч компаниасаа шууд тодруулах боломжтой юм.
- ✧ Мөн дээрх бүх талбайд SBT-ын яард хариуцсан 2 ажилтан ээлжлэн ажилладаг бөгөөд танд газар дээр нь олон төрлөөр тусламж үзүүлэх болно.

IV алхам. Даатгалийн үйлчилгээ сонгох

Манай улс далайд гарцгүй улс бөгөөд таны авсан машин далайг гаталж, эх газрын олон шат дамжлагыг давж таны гарт ирдэг. Бид хамгийн чанартай, чанга бэхэлгээг хийх боловч олон шат дамжлагатай тээвэрлэлтийн үед асуудал үүсэх, хохирол амсахгүй гэх баталгаа үгүй билээ.

Иймд бид харилцагчдынхаа ирээдүйд учирч болох санхүүгийн эрсдлээс хамгаалж хамгийн үр дүн өндөртэй буцаан олголт хийж чаддаг даатгалийн үйлчилгээгээ танд санал болгож байна.

- ✓ Та өөрийн худалдаж авсан машинаа тээвэрлэлтийн явцад үүсэж болох эрсдэлээс хамгаалж нийт үнийн дүнгийн 1% аар даатгуулах боломжтой. Харин бид тээвэрлэлттэй холбоотой учирсан хохирлыг 99% шийдэж өгөх болно.
- ✓ Даатгалтай холбоотой дэлгэрэнгүй мэдээллийг хавсралтаас үзнэ үү.

V алхам. Төлбөр төлөлт

Төлбөрийн нэхэмжлэл нь системээс таны бүртгэлтэй цахим шууданд автоматаар очно. Худалдан авалтын хэмжээнээс хамаарч төлбөрийн нэхэмжлэлийг олон төрлөөр авах боломжтой бөгөөд энэ тухай худалдааны зөвлөхдөө хэлэхэд л болно.

- ✓ Урьдчилгаа төлбөрийг машин худалдан авснаас хойш 10 хоногийн дотор шилжүүлэх ёстой
- ✓ Үлдэгдэл төлбөрийг машин Японы газар нутгаас хөдөлснөөс хойш 14 хоногийн дотор төлөх ёстой

Шилжүүлэг хийх өдөр хэтэрвэл: ХАДГАЛАЛТЫН ЗАРДАЛ болон ТОРГУУЛЬ үүсэх эрсдэлтэй. Мөн машины ЕКСПОРТ СЕРТИФИКАТ Монголд хоцорч очих эрсдэлтэй тул цагт нь шилжүүлж байна уу.

- ✓ Төлбөрийг та аль ч банкны гадаад гуйвуулгаар шилжүүлэх боломжтой
- ✓ Шаардлагатай бичиг баримт нь **Төлбөрийн нэхэмжлэл** болон **Иргэний үнэмлэх**.

Санамж:

Харилцагч та төлбөрөө шилжүүлэхдээ өөрийн биеэр банкны салбар болон онлайн үйлчилгээ ашиглана уу. Хувь хүний данс болон Валютын ченжээр дамжуулахыг хатуу хориглох ба энэ нь ХУУЛЬ БУС ГҮЙЛГЭЭ бөгөөд үүнээс үүдэн гарах хохирол, эрсдэлийг SBT компани хариуцахгүй болно.

Захиалга хүлээн авах зааварчилгаа

I алхам. SBT- Бичиг баримт бүрдүүлэлт

Та манай Монгол дахь оффисоос дараах бичиг баримтыг ирж авна.

- ❖ Автомашины Экспортын Сертификат
- ❖ Төлбөрийн баримт

II алхам. Тээвэр зуучийн компани дээр төлбөр төлөлт

Тээвэр зуучин компани дээр очин Японоос Монгол хүртэлх тээврийн зардалыг төлж, төлбөрийн баримт болон бусад холбогдох баримт бичгүүдийг авна.

Тээвэр зуучийн компани тус бүр өөр өөр дотоод дүрэм журамтай тул дэлгэрэнгүй мэдээллийг тухайн компаниас нь авна уу.

III алхам. Гаалийн бүрдүүлэлт

Тухайн машин УБ хотын аль гаалийн талбай дээр бууж байгаагаас хамаарч тухайн газрынхаа салбар Гаалийн байгууллагад хандан машинаа гаалиар оруулах бүрдүүлэлтийг хийнэ. Гаалийн татвараа төлж бусад холбогдох баримт бичгийг бүрдүүлснээр машинаа гаалийн талбайгаас гаргах боломжтой болно.



SBT CO., LTD - Global Car Exporter
KDX Yokohama-Nishiguchi Bldg. 7F, 2-10-36 Kitasaiwai Nishi-ku, Yokohama Kanagawa 220-0004 Japan
Phone: +81-45-290-9485 email:infomongola@sbtjapan.com

Хүснэгт1: Нэгдсэн үнэлгээ

Үнэлгээ ний оноо	км-ын гүйлт	Гадна тал	Дотор тал	Гадна болон дотор талын зэрэг	бусад
		Үнэлгээ	Үнэлгээ		
S	10,000Km дотор	A ранк	A ранк	Бараг бүрэн бүтэн, засвар хийгээгүй	Бүртгүүлээд 1 жил болоогүй байна
6	30,000Km дотор	дээрхтэй адил	дээрхтэй адил	Бараг бүрэн бүтэн, засвар хийгээгүй, засвар шаарддаггүй	Хөдөлгүүр ба тэнхлэг торхиргоо сайтай
5	60,000Km дотор	дээрхтэй адил	дээрхтэй адил	Хэдийгээр үл анзаарагдам зураас, хонхорхой байгаа ч дотор болон гадна талдаа засвар хийх шаардлага бараг байхгүй.	Хөдөлгүүр ба тэнхлэг торхиргоо сайтай
				Гаднах давхаргын хэсгүүдийг солих шаардлагүй	
4.5	100,000Km дотор	B ранк, түүнээс дээш	B ранк, түүнээс дээш	Дотор болон гадна талдаа бага зэргийн засвар хийснээр 5 оноотой тэнцэнэ	
4	150,000Km дотор	C ранк, түүнээс дээш	C ранк, түүнээс дээш	Зарим нэг мэдэгдэхүйц зураас, хонхорхой, зэв, түлэгдэл, баг зэрэг урагдал байгаа тул засах шаардлагатай гэж бодож байна.	
3.5	дээрхээс их	D ранк, түүнээс дээш	D ранк, түүнээс дээш	Том, жижиг хэмжээтэй засвар хийх шаардлагатай хэд хэдэн газар бий	
				Хэд хэдэн түлэгдсэн болон урагдсан зүйлс бий	
3	дээрхээс их	E ранк, түүнээс дээш	E ранк, түүнээс дээш	Бүрэн засвар, солих, шинэчлэх шаардлагатай зүйлс бий	
2	• санамсаргүй байдлаар эвдрэл гэмтэл, томоохон өөрчлөлтөд орсон. • Энэ нь оргинал хөдөлгүүргүй ч байж болно. • Машинд турбо гэх мэт үйлдвэрийн бус хоёрдогч бүрэлдэхүүнийг суурилуулсан байж болно. • Машинд зэврэлт, зэвний шинж тэмдэг ихээр илэрч болно.				даатгалд хамрагдах боломжгүй
1	Гамшигт өртсөн машин (нурам, мөндөр, усанд живсэн машин г.м.), чанар муутай автомашин, тэмцээнд ашигласан машин (ралли, шороон туршилт гэх мэт)				даатгалд хамрагдах боломжгүй
RA	• Машинд санамсаргүй байдлаар эвдрэл гэмтэл гарч, засч залруулсан байж болзошгүй. • Үнэлгээний зэрэг нь тээврийн хэрэгслийн насжилт, мильтай ямар ч холбоогүй болно. • Мөн 3 сараас доош настай хэрнээ санамсаргүй байдлаар гэмтсэний улмаас уг үнэлгээ өгсөн магадлалтай.				даатгалд хамрагдах боломжгүй
R / A	• Томоохон осолд орсон машин • Биеийн нэг буюу хэд хэдэн томоохон хэсгийг сольсон, зассан • Мөн эвдэрч гэмтсэний улмаас хөдөлгүүр, дотоод эд ангиуд ажиллахгүй байж болно.				даатгалд хамрагдах боломжгүй
***	Үнэлэхэд хэцүү машин, осолд орсон болон эвдэрлээс болоод явахгүй эсвэл хуулбарласан машин				даатгалд хамрагдах боломжгүй

Хүснэгт2: Гадна талын үнэлгээ

Үнэлгээ	Үнэлгээний шалгуур		
A ранк	1 . 2-3 газарт 2-3 см орчим жижиг зураас болон хонхорхой		
	2 . Будаг орсон боловч тэр нь нүдэнд үл мэдэгдэх хэмжээтэй		
B ранк	1 . 5 - 20 см-ийн зураас, хэд хэдэн гольфын бөмбөгний хэмжээтэй хонхорхойтой		
	2 . Будаг орсон, бага зэргийн давалгаатай зүйл		
	3 . Шил (цуурал, шил арчигчийн зураастай) Хагарсан		
C ранк	1 . B ранкийг бодвол зураас, хонхорхой олонтой		
	2 . 20-40см зураастай хэд хэдэн газарт бий		
	3 . Гарын алганы хэмжээтэй хонхорхой 2 ~ 3газарт байгаа		
	4 . Будаг орсон том давалгаатай, бага зэрэг өнгө нь зөрсөн, халцарсан		
D ранк	1 . Том хэмжээний зураас хэд хэд байгаа		
	2 . Том хэмжээний хонхорхой хэд хэдэн газарт байгаа		
	3 . Солих шаардлагатай хэмжээний том хонхорхой, зураастай		
	4 . Будсан боловч дахин засварлах шаардлагатай		
	5 . Зэв ихтэй		
	6 . Зэвэнд идэгдсэн		
E ранк	1 . BODY- гадар бие нь засвар хийх шаардлагатай (зураас хонхорхой ихтэй, өнгө хувирсан, халцарсан гэх мэр)		
	2 . Зэвтэй, зэвэнд идэгдсэн хэсэг маш их		

Хүснэгт3: Дотор талын үнэлгээ

Үнэлгээ	Үнэлгээний шалгуур		
A ранк	Засвар хийх шаардлагагүй, эсвэл маш бага, тэр чигт нь байгаагаар нь үзэсгэлэн гаргаж зарж болно		
	1. Үл мэдэгдэх урагдалт, хөнгөн түлэгдсэн ором, эсвэл амархан арилдаг толбо нийт 2-3 л байгаа		
	2. Том хэсэг алга болоогүй байна		
B ранк	Засвар хийх шаардлага багатай, эсвэл энэ нь арилжааны үнэд ихээхэн нөлөө байхгүй		
	1. Жижиг хэмжээний урагдалт, хөнгөн түлэгдсэн ором, утас нь сөрдийсөн, хэд хэдэн нүх гарсан		
	2. жижиг түлэгдсэн нүх, хяналтын самбар дээр жижиг зүйлс		
	3. Амархан цэвэрлэж болохоор бохирдол		
C ранк	Бага зэргийн засвар хийх шаардлагатай, тэр нь арилжааны үнэд нөлөөлхүйц зүйлс		
	1. Түлэгдсэн, түлэгдсэн нүх, сэмэрсэн, урагдсан. Нүдэнд өртөхөөр нүх, урд салоны доторх нь хайлж хөөсөн, жижиг хагарал гэх мэт байгаа		
	2. Бохирдолтой зүйлс ихтэй, гэхдээ цэвэрлээд арилах боломжтой		
D ранк	Засварлах шаардлагатай зүйлстэй		
	1. Олон тооны түлэгдсэн нүх, толбо гэх мэт зүйлээс болж шинээр солих, хучих шаардлагатай эд зүйлс.		
	2. Удирдах самбар, урд салон нь томоохон өөрчлөлт орсон, хэлбэрээ өөрчилсөн		
	3. Цэвэрлэгээ хийгээд ч арилахгүй бохирдол ихтэй		
E ранк	Их засвар хийх шаардлагатай		
	1. Удирдах самбар дээрх том цуурал, хагархайтай, солих шаардлагатай		
	2. Хана, тааз, шал болон суудлын бүрээс нь маш их бохирдолтой, урагдсан түлэгдсэн зүйлс ихтэй		
	3. Дотор тал маш муухай үнэртэй, энэ чигт нь худалдахаар үзэсгэлэнд тавих боломжгүй		



SBT CO., LTD - Global Car Exporter
KDX Yokohama-Nishiguchi Bldg. 7F, 2-10-36 Kitasaiwai Nishi-ku, Yokohama Kanagawa 220-0004 Japan
Phone: +81-45-290-9485 email:infomongola@sbtjapan.com

1. ХЯНАЛТЫН ТЭМДЭГ

A1	Зураас (жижиг)	E1	жижиг (хацрын мэт) хонхорхой
A2	Зураас (2 алганы хэмжээ)	E2	хэд хэдэн (хацрын мэт) хонхорхой
A3	Зураас (A2-оос том)	E3	маш олон (хацрын мэт) хонхорхой
U 1	Хонхорхой (эрхий хурууны хэмжээ)	H	хууларсан эсвэл нүх гарсан
U 2	Хонхорхой (алганы хэмжээ)	G	цонхонд чулуу үсэрсэн мөр
U 3	Хонхорхой (U 2-оос том)	K	өөтэй, алдаатай
AU1	Зураас, хонхорхой (жижиг)	R	Салхины шилний хагарлыг засч янзалсан
AU2	Зураас, хонхорхой (дунд)	R X	Салхины шил хагарсан, солих шаардлагатай
AU3	Зураас, хонхорхой (том)	X	солих шаардлагатай
B 1	Зураас, хонхорхой (маш жижиг)	XX, XXX	солисон
B 2	Зураас, хонхорхой (жижиг)		
B 3	Зураас, хонхорхой (B 2-оос том)		
B 4	Зураас, хонхорхой (маш том)		
W1	Доголтой гадаргууг зассан (сайн)	キズ	зураас
W2	Доголтой гадаргууг зассан (дунд)	スレ / スリ	зураас (шалбархай)
W3	Доголтой гадаргууг зассан (нүдэнд өртөхөөр)	ハゲ	өнгө нь халцарсан
Y1	Цуурсан (эрхий хурууны хэмжээ)	サビ	зэв
Y2	Цуурсан (алганы хэмжээ)	ヒビ / フレ	цуурсан / хагарсан
Y3	Цуурсан (Y2-аас том)	凹 / ヘコミ	хонхойж орсон
S1	Зэвэрсэн (жижиг)	ヤブレ / 破れ	урагдсан
S2	Зэвэрсэн (дунд зэрэг)	ヨゴレ / 汚れ	бохирдсон
S3	Зэвэрсэн (маш их)	コゲ	түлэгдсэн
C 1	Зэвэнд идэгдсэн (жижиг)	穴	нүх
C 2	Зэвэнд идэгдсэн (дунд болон нүх гарсан)	トビ / 石	чулуу үсэрсэн мөр
C 3	Зэвэнд идэгдсэн (маш их)	腐食	зэвэнд идэгдсэн
P1	Өнгө халцарсан (жижиг)	波	тэгш бус доголтой гадаргуу
P2	Өнгө халцарсан (дунд)	小	жижиг хэмжээтэй
P3	Өнгө халцарсан (том)	中	дунд хэмжээтэй
		大	том хэмжээтэй

A. Transmission Code

AT / FA	Automatic Transmission
CA / CAT	Column Automatic Transmission
DA / DAT	Dashboard Automatic Transmission
CVT	Continuously Variable Transmission
MT	Manual Transmission
F5 5	Speed Manual Transmission
F6 6	Speed Manual Transmission TIP Tiptronic

B. Common Option

AC	Air Conditioner
AAC	Climate Control Air Conditioner
WAC / WAA	Double Air Conditioner
PS	Power Steering
PW / EW	Power Windows
PM	Power Mirrors
CL	Central Locking
HR	Highroof
SR	Sunroof
CD	CD Player
MD	MD Player
TV	Television (only in Japan)
NAVI / ナビ	Navigation (only in Japan)
LS / カワ	Leather Seats
純AW	Genuine Alloy Wheels
AW	Alloy Wheels
ABG / SRS / エアＢ	Airbag
ABS	Anti Lock Brake System
ESC /ESP	Electronic Stability Control
HID	High-intensity Discharge Headlamps

C. Other Option (alphabetical)

AFS	Adaptive Front Light System	LSD	Limited Slip Differential Power
AL / AHL	Auto Headlights	LWB	Long Wheel Base
ASR	Acceleration Skid Control	OP	Optitron Meter
ATSR	Auto Sunroof	PSR	Panoramic Sunroof
AU	Steering Audio Control	R A	Roof Antenna
BB	Bull Bar	R M	Rear Mirror
BT	Bluetooth	R R	Roof Rails
C&Bsonar	Corner & Back Sensor	R S	Rear Spoiler
CAB	Curtain Side Airbag	R W	Rear Wiper
CC	Cruise Control	SAR	Seat Arm Rest
CP	Corner Pole	SET	Stainless Steel Exhaust Tip
CS	Cassette Stereo / Corner Sensor	SH	Seat Heater
EBD	Electronic Brakeforce Assist Distribution	SL	Spot Lights
ECP	Electric Corner Pole	SM	Snow Mode Drive
EFI	Electric Fuel Injection	SP	Spoiler
EIS	Engine Immobilizer System	SS	Side Step
EPC	Electronic Power Control	SSus	Sports Suspension
EPS	Engine Push Start	ST	Stereo
ES	Electric Seats	SWB	Short Wheel Base
F&S	AB Front & Side Airbag	T	Spare Tire
F.S.R.	Front, Side, Rear Aero Parts	TC	Twin Cam
FL	Fog Lamps	TRC / TCS	Traction Control System
FP	Front Pole	VDC / DSC	Vehicle Dynamics Control
GG	Grille Guard	VSA	Vehicle Stability Assist
H D	Highdeck	WAB	Dual Front Airbag
HDC	Hill Descend Control	工口	Aero Kits
HDD	Hard Disc Storage Audio		
H L	Headlight Levelizer		
HSA	Hill Start Aid		

2. ЖИЛ ХУВИРГАЛТ

平成	12	2000	平成	23	2011
平成	13	2001	平成	24	2012
平成	14	2002	平成	25	2013
平成	15	2003	平成	26	2014
平成	16	2004	平成	27	2015
平成	17	2005	平成	28	2016
平成	18	2006	平成	29	2017
平成	19	2007	平成	30	2018
平成	20	2008	平成 / 令和	31, 1	2019
平成	21	2009	令和	2	2020
平成	22	2010	令和	3	2021



SBT – ДААТГАЛ

Харилцагчид зориулсан гарын авлага

SBT CO., LTD - Global Car Exporter

KDX Yokohama-Nishiguchi Bldg. 7F, 2-10-36 Kitasaiwai Nishi-ku, Yokohama Kanagawa 220-0004 Japan

Phone: +81-45-290-9485 email: infomongola@sbjapan.com

1 Ямар машинууд даатгалд хамрагдах боломжтой бэ?

☆ Нэгдсэн үнэлгээний оноо нь S ээс 3 хүртэл

Хүснэгт1: Нэгдсэн үнэлгээ

Үнэлгээний оноо	км-ын гүйлт	Дотор тал	Гадна тал	Дотор болон гадна талын зэрэг	бусад
		Үнэлгээ	Үнэлгээ		
S	10,000Km дотор	A ранк	A ранк	Бараг бүрэн бүтэн, засвар хийгээгүй	Бүртгүүлээд 1 жил болоогүй байна
6	30,000Km дотор	дээрхтэй адил	дээрхтэй адил	Бараг бүрэн бүтэн, засвар хийгээгүй, засвар шаарддаггүй	Хөдөлгүүр ба тэнхлэг торхиргоо сайтай
5	60,000Km дотор	дээрхтэй адил	дээрхтэй адил	Хэдийгээр үл анзаарагдам зураас, хонхорхой байгаа ч дотор болон гадна талдаа засвар хийх шаардлага бараг байхгүй.	Хөдөлгүүр ба тэнхлэг торхиргоо сайтай
				Гаднах давхаргын хэсгүүдийг солих шаардлагүй	
4.5	100,000Km дотор	B ранк, түүнээс дээш	B ранк, түүнээс дээш	Дотор болон гадна талдаа бага зэргийн засвар хийснээр 5 оноотой тэнцнэ	
4	150,000Km дотор	C ранк, түүнээс дээш	C ранк, түүнээс дээш	Зарим нэг мэдэгдэхүйц зураас, хонхорхой, зэв, түлэгдэл, баг зэрэг урагдал байгаа тул засах шаардлагатай гэж бодож байна.	
3.5	дээрхтэй адил	D ранк, түүнээс дээш	D ранк, түүнээс дээш	Том, жижиг хэмжээтэй засвар хийх шаардлагатай хэд хэдэн газар бий	
				Хэд хэдэн түлэгдсэн болон урагдсан зүйлс бий	
3	дээрхтэй адил	E ранк, түүнээс дээш	E ранк, түүнээс дээш	Бүрэн засвар, солих, шинэчлэх шаардлагатай зүйлс бий	
2	• санамсаргүй байдлаар эвдрэл гэмтэл, томоохон өөрчлөлтөд орсон. • Энэ нь оргинал хөдөлгүүргүй ч байж болно. • Машинд турбо гэх мэт үйлдвэрийн бус хоёрдогч бүрэлдэхүүнийг суурилуулсан байж болно. • Машинд эвэрлэлт, зэвний шинж тэмдэг ихээр илэрч болно.				даатгалд хамрагдах боломжгүй
1	Гамшигт өртсөн машин (нурам, мөндөр, усанд живсэн машин г.м.), чанар муутай автомашин, тэмцээнд ашигласан машин (ралли, шороон туршилт гэх мэт)				даатгалд хамрагдах боломжгүй
RA	• Машинд санамсаргүй байдлаар эвдрэл гэмтэл гарч, засч залруулсан байж болзошгүй. • Үнэлгээний зэрэг нь тээврийн хэрэгслийн насжилт, мильтай ямар ч холбоогүй болно. • Мөн 3 сараас доош настай хэрнээ санамсаргүй байдлаар гэмтсэний улмаас уг үнэлгээ өгсөн магадлалтай.				даатгалд хамрагдах боломжгүй
R / A	• Томоохон осолд орсон машин • Биеийн нэг буюу хэд хэдэн томоохон хэсгийг сольсон, зассан • Мөн эвдэрч гэмтсэний улмаас хөдөлгүүр, дотоод эд ангиуд ажиллахгүй байж болно.				даатгалд хамрагдах боломжгүй
***	Үнэлэхэд хэцүү машин, осолд орсон болон эвдэрлээс болоод явахгүй эсвэл хуулбарласан машин				даатгалд хамрагдах боломжгүй

Хүснэгт2: Гадна талын үнэлгээ

Үнэлгээ	Үнэлгээний шалгуур		
A ранк	1. 2-3 газарт 2-3 см орчим жижиг зураас болон хонхорхой		
	2. Будаг орсон боловч тэр нь нүдэнд үл мэдэгдэх хэмжээтэй		
B ранк	1. 5 - 20 см-ийн зураас, хэд хэдэн гольфын бөмбөгний хэмжээтэй хонхорхойтой		
	2. Будаг орсон, бага зэргийн давалгаатай зүйл		
	3. Шил (цуурал, шил арчигчийн зураастай) Хагарсан		
C ранк	1. B ранкийг бодвол зураас, хонхорхой олонтой		
	2. 20-40см зураастай хэд хэдэн газарт бий		
	3. Гарын алганы хэмжээтэй хонхорхой 2~3газарт байгаа		
	4. Будаг орсон том давалгаатай, бага зэрэг өнгө нь зөрсөн, халцарсан		
D ранк	1. Том хэмжээний зураас хэд хэд байгаа		
	2. Том хэмжээний хонхорхой хэд хэдэн газарт байгаа		
	3. Солих шаардлагатай хэмжээний том хонхорхой, зураастай		
	4. Будсан боловч дахин засварлах шаардлагатай		
	5. Зэв ихтэй		
	6. Зэвэнд идэгдсэн		
E ранк	1. BODY- гадар бие нь засвар хийх шаардлагатай (зураас хонхорхой ихтэй, өнгө хувирсан, халцарсан гэх мэр)		
	2. Зэвтэй, зэвэнд идэгдсэн хэсэг маш их		

Хүснэгт3: Дотор талын үнэлгээ

Үнэлгээ	Үнэлгээний шалгуур		
A ранк	Засвар хийх шаардлагагүй, эсвэл маш бага, тэр чигт нь байгаагаар нь үзэсгэлэн гаргаж зарж болно		
	1. Үл мэдэгдэх урагдалт, хөнгөн түлэгдсэн ором, эсвэл амархан арилдаг толбо нийт 2-3 л байгаа		
	2. Том хэсэг алга болоогүй байна		
B ранк	Засвар хийх шаардлага багатай, эсвэл энэ нь арилжааны үнэд ихээхэн нөлөө байхгүй		
	1. Жижиг хэмжээний урагдалт, хөнгөн түлэгдсэн ором, утас нь сөрдийсөн, хэд хэдэн нүх гарсан		
	2. жижиг түлэгдсэн нүх, хяналтын самбар дээр жижиг зүйлс		
	3. Амархан цэвэрлэж болохоор бохирдол		
C ранк	Бага зэргийн засвар хийх шаардлагатай, тэр нь арилжааны үнэд нөлөөлхүйц зүйлс		
	1. Түлэгдсэн, түлэгдсэн нүх, сэмэрсэн, урагдсан. Нүдэнд өртөхөөр нүх, урд салони доторх нь хайлж хөөсөн, жижиг хагарал гэх мэт байгаа		
	2. Бохирдолтой зүйлс ихтэй, гэхдээ цэвэрлээд арилах боломжтой		
D ранк	Засварлах шаардлагатай зүйлстэй		
	1. Олон тооны түлэгдсэн нүх, толбо гэх мэт зүйлээс болж шинээр солих, хучих шаардлагатай эд зүйлс.		
	2. Удирдах самбар, урд салон нь томоохон өөрчлөлт орсон, хэлбэрээ өөрчилсөн		
	3. Цэвэрлэгээ хийгээд ч арилахгүй бохирдол ихтэй		
E ранк	Их засвар хийх шаардлагатай		
	1. Удирдах самбар дээрх том цуурал, хагархайтай, солих шаардлагатай		
	2. Хана, тааз, шал болон суудлын бүрээс нь маш их бохирдолтой, урагдсан түлэгдсэн зүйлс ихтэй		
	3. Дотор тал маш муухай үнэртэй, энэ чигт нь худалдахаар үзэсгэлэнд тавих боломжгүй		

2 Даатгалд хамрагдвал хичнээн иен нэмж төлөх бэ

- ☆ Нийт үнийн дүнгийн 1% бөгөөд таны авсан машины үнийн дүнгээс хамаарна

3 Даатгалд хамрагдвал ямар хохирлыг нэхэмжлэх боломжтой бэ?

- ☆ Машин Монголд хүрснээс 30 хоногийн дотор Claim үүсгэх боломжтой
- ☆ Тээвэрлэлтийн явцад гарсан хохирол, эвдрэл гэмтлийг нэхэмжилж болно. Тухайн гэмтэл, хохирол нь: Auction sheet болон YARD дээрх дэлгэрэнгүй зурагт байхгүй байх
- ☆ Auction-оос худалдаж авах үеийн sheet дээрх мэдээлэл, монголд машин буух үед зөрүүтэй байх үед нэхэмлэх боломжтой
- ☆ Зураг дээрх жижиг гэмтлүүд нь хамрагдах боломжгүй



4 Даатгалд хамрагдсан машин CLAIM гарсан тохиолдолд юу юу бүрдүүлэх хэрэгтэй бэ?

- Хүсэлт явуулах дараалал Харилцагч →Худалдааны зөвлөх эсвэл Ахлах менежерт →Claim team of SBT HQ
- ☆ Машины эвдрэл гэмтэлийг баталгаажуулсан баримт болон зураг
Контэйнер задрах үеийн зураг заавал байх, контэйнерийн дугаар заавал орсон байна / Зураг хэрхэн авах заавар хавсаргав /
- ☆ Засварын газрын төлбөрийн баримт, нэхэмжлэл

5 CLAIM Шийдэгдтэл хэр хугацаа шаардлагатай бэ?

- ☆ Бүх материал нь бүрэн асуудалгүй бол ажлын 5 хоногт шийдвэрлэгдэж, удаандаа 1 сар болно.

6 REFUND - нэхэмжлэлийн буцаан олголт хийх

- ☆ Буцаалт хийх 2 сонголт байгаа

1 Манайхаас байнга машин авдаг харилцагч бол дараагийн машины зардлыг

2 ENDUSER буюу нэг л удаа үйлчлүүлж байгаа харилцагч бол өөрийн Монгол дах дансанд нь буцаалт хийх боломжтой

- ☆ Шилжүүлгийн шимтгэлийг SBT хариуцна.

Дараах материалууд хэрэгтэй.


- ☆ ТТ сору – тухайн машины төлбөрийн шилжүүлгийн баримт /мөнгөн дүн, харилцагчийн нэр, дансны мэдээллүүд таарч байх шаардлагатай/
- ☆ Гадаад паспортын зураг /зурагтай хуудас нь/
- ☆ Банкны тодорхойлолт /энэ хүн энэ дансийг эзэмшиж буй нь үнэн гэх мэдээлэл байна. /
- + Харилцагчийн гарын үсэгтэй захидал /SBT - ээс харилцагч руу явуулна/

- ☆ Харилцагчаас шилжүүлэг хийхтэй холбоотой материал хүлээн авснаас хойш ажлын 5 хоногт шилжүүлэг хийгдэнэ.
- ☆ Эндээс шилжүүлэг хийгдмэгц банк хооронд асуудал гарахгүй бол ажлын 3хоногт монгол дах дансанд орох болно.



Зураг авах зааварчилгаа:

1 Контейнерын хаалга онгойлгох үеийн зураг 3ш



2 Клайм мэдүүлэх гэж байгаа машиныг бэхлэгчээс салгагүй байх үеийн зураг контейнер дугаарыг хамтад нь гаргасан байх => боломжтой бол тухайн машиныг нь бүх талаас нь баруун, зүүн, дээд, доод, урд хойд хэсгийн зургууд 5-8 ш





3 Клайм мэдүүлэх гэж байгаа машиныг бэхэлгээнээс салгасны яг дараа нь Гаалийн талбайгаас гараагүй байх үеийн зураг =>
гэмтэлтэй хэсгийн 3 талаас нь бүтнээр нь авсан байна 3-5ш



4 Гэмтэлтэй хэсгийн зургийг бүтнээс нь жижигрүүлэн деталчилж авсан зураг 3-5 ш / зураг авах байршил нь контейнер эсвэл гаалийн талбайд дотор аль нь ч болно/

